

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

УЛС ТӨР

БОАЖЯ БАЙГАЛЬ ОРЧНЫ ИРГЭНИЙ ЗӨВЛӨЛТЭЙ ХАМТАРЛАА

II нүүрт

ОНЦЛОХ ХУУДАС

НИЙГЭМД ТАНИГДААГУЙ, УЛС ТӨРД ШИНЭ ДЭД САЙДУУД

V нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ХОХЬ НЬ БОЛЖ БАЙНА ДАА

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улс дэлхийн хамгийн хүчирхэг хоёр их гүрний дунд хавчуулагдсан азгүй, бас азтай улс. Уг нь хоёр талд байгаа энэ том хоёр гүрний эдийн засгийн боломж талаас нь ашиглаж чадвал манайх азтай улс шүү дээ. Дээрээс нь Монгол Улсын газар нутаг тун онцлог. Ази, Европыг холбох хамгийн дөт зам гэх мэтээр хараад үзвэл. Харамсалтай нь манайх 20 гаруй жил хоосон улстөржиж суусаар бүх боломжийг алдлаа. Өнөөдөр Монголд ирэх сонирхолтой хөрөнгө оруулагч ч гэж алга. Саяхан УИХ-ын дарга М.Энхболд ярьж байсан.

Гадны хөрөнгө оруулагчдын ихэнх нь Монголын хяналтын байгууллагуудын дарамтаас болж "үргэсэн" гэсэн судалгааны дүн гарсан талаар. Мөн гадаадын хөрөнгө оруулагчид Монголоос биш манай дарга нарын "Надад ямар ашигтай юм, хэдэн хувийг нь өгөх вэ" гэдэг шуналаас зугтсан гэдэг онч үг ч гараад байгаа. Ерөөсөө сүүлийн жилүүдэд төрд гарсан эрх мэдэлтнүүд, дарга нар хий улстөржиж, хэрэлдэж, өөрийнхөө эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, олон ажлыг унагаж, нураасан. Түүний "ачаар" өнөөдөр хоёр хөрш манайхыг зүгээр л "жийж" орхиод байна.

Үргэлжлэл нь III нүүрт

Улаанбаатарт: **ӨНӨӨДӨР**

Өдөр -16
Шөнө -25

Дугаарын **60** мөр

Нэрэлхэлгүй, хороолгүй баяраа тэмдэглэе

Н.БАТЗАЯА

Хүн хэдий ухаантай ч хэлэхээс нааш санадаггүй, цаас хэдий нимгэн ч чичихээс нааш цоордоггүй гэдэг. Тиймээс энд дахиад нэгэн мөнхийн сэдвийг хөндө. Учир юу гэвээс биднийг улстөрчдийн хий хоосон яриаг сонсож, аманд нь орох шахам байхад аль хэдийнэ цагаан сар гэх нүсэр ажлын анхааруулах шар гэрэл асчээ. Ингээд хэлэхээр миний өгүүлэх сэдэв тун ойлгомжтой болж буй биз. Жил бүр бид цагаан сарын баяр дөхөхтэй зэрэгцээд ирсэн зочдынхоо гарыг цайлгах бэлэг гэгч айхтар зүйлийн эрэлд гарцгаадаг. Энэ нь нэг хэсэгтээ л Монголын ард түмний толгойны өвчин болдог гэхэд болно. Дарь нь дээр давс гэгчээр ирсэн зочиндоо аятайхан, хэн нэгнээс дутахааргүй, нүүрээ уулзуулахааргүй бэлэг өгөөд гаргачих юмсан гэсэн монголчуудын нэрэлхүү зан хэрэг явдлыг улам хүндрүүлдэг гэхэд хилсдэхгүй.

Үргэлжлэл нь III нүүрт

О.БАТ-ЭРДЭНЭ:

ГАДААД, ДОТООД ХАРИЛЦААГАА САЙЖРУУЛЖ, ХУВИЙН ХЭВШЛЭЭ БОДЛОГООР ДЭМЖИЖ БАЙЖ БАЯЛАГ БҮТЭЭХ НЬ БИДНИЙ ЗОРИЛГО

Дэлгэрэнгүй ярилцлагыг VI-VII нүүрнээс

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 ДЭХ ЖИЛДЭЭ

Манай сонины I улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ 19800

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

Ц.ЭЛБЭГДОРЖ: Эхийн хэвлийд ураг амьгүй болж байна, үүнийг аюулгүй гэхгүй бол өөр юуг гамшиг гэх юм



Гэрэл зурагийг Г.АРГУУЖИН

Н.ПУНЦАГБОЛД

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өчигдөр Төрийн ордон дахь "Иргэний танхим"-д сэтгүүлчидтэй уулзаж, "Нийслэлийн агаарын бохирдлын тухай" хэлэлцлээ. Тэрбээр мэдээллийн эхэнд өнгөрсөн мягмар гарагт хуралдсан УАБЗ-ийн хурлаар ямар шийдвэр гаргасан талаар тайлагнасан юм. Мөн өөрийнхөө хийж хэрэгжүүлсэн ажил, санаачилсан санаачилга болоод үзэл бодлоо ч илэрхийлэхээ мартаагүй. Тэрбээр "Нийслэл хотын агаар, орчны бохирдлын асуудлыг өчигдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл өргөтгөсөн хурлаар авч хэлэлцсэн. Хуралдаанд төрийн өндөрлөгүүд, сайдууд, УИХ-ын гишүүд, хотын удирдлагууд оролцсон. Үндсэндээ 12 байгууллагын төлөөлөл оролцсон. Ер нь ийм хурал хийнэ гэж төлөвлөж байсан. Хамгийн гол нь маш олон төлөөллийг бүгдийг нь оруулж ирж, суулгаж ярилцсан нь ач холбогдолтой болсон.

Үргэлжлэл нь II нүүрт

ДЭЛХИЙ

БАРАК ОБАМАГИЙН ҮДЭЛТИЙГ ҮГЭЭС ОНЦЛОХ 10 ИШЛЭЛ

Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль өнгөрсөн оны арваннэгдүгээр сарын 8-нд явагдаж, Бүгд найрамдах намаас нэр дэвшсэн үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп ялалт байгуулсан билээ. Тэрбээр энэ сарын 20-нд тангаргаа өргөж, албан ёсоор АНУ-ын 45 дахь Ерөнхийлөгч

болох юм. Харин эсрэгээр нэг удаа улиран сонгогдож, нийтдээ найман жилийн турш тус улсыг удирдсан Ерөнхийлөгч Барак Обамагийн бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж байна. Тэрбээр 2008 онд анх АНУ-ын Ерөнхийлөгчөөр сонгогдож, анхны өнгөт арьст Ерөнхийлөгч болж байсан билээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк					
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах	
АМ.ДОЛЛАР	2494.00	2505.00	ФУНТ	2992.00	3092.00	АМ.ДОЛЛАР	2493.00	2505.00	
ЕВРО	2604.00	2671.00	РУБЛЬ	39.80	43.30	ЕВРО	2605.00	2679.00	
ИЕН	21.36	21.66	ЮАНЬ	358.50	363.90	ИЕН	21.30	21.92	
							ФУНТ	3008.00	3091.00
							РУБЛЬ	40.21	43.93
							ЮАНЬ	359.00	364.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

ҮЗЭЛ БОДОЛ

Дугаарын **60** мөр

ҮЗЭЛ БОДОЛ

Нэрэлхэлгүй, хороолгүй баяраа тэмдэглэе

Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Үнэн хэрэгтэй цагаан сараар аав, ээж, ах, дүү төрөл төрөгсөд гээд ирсэн зочдын гарыг хоосон буцаадаггүй ардын сайхан уламжлалыг л цагийн аясаар өөрчилчихсэн. Дээхэн үед цагаан сараар ирсэн зочиндоо хавсай, идээ, тос хүүхдүүдэд нь дэвтэр, бал, ётон өгөөд л гаргадаг байсан гэдэг. Тиймээс нэрэлхээд нэрээ идэх биш дээ, энэ жил хөнгөлийнхөө хэрээр хөлөө жийчихвэл яасан юм. Тэртээ тэргүй 2017 онд манай улсын эдийн засаг элгээрээ мөлхөнө, одоо байгаагаасаа ч дордох магадлалтай гэдгийг мэргэжилтнүүд сануулаад байгаа шүү дээ. Гуравхан сая монголчууд тэднийх тийм бэлэг өглөө, эднийх ийм бэлэг өгчихлөө гэж бие биенээ гоочлоод ч яах юм билээ. Тэр бүү хэл хятадын эрэн, мяраан чанартай, чанаргүй, өнгө үзэмж муутайхан барааг худалдан авч гадаадын зах зээлд хөрөнгө оруулалж байхаар үндэснийхээ үйлдвэрийг дэмжэе л дээ. Жил бүр л үндэснийхээ үйлдвэрийг дэмжиж, сар шинийн бэлгээ дотоодод үйлдвэрлэсэн бараагаар бэлдэе гэдэг уриалга гаргадаг. Тэгвэл энэ жил энэ уриалгыг жинхэнэ утгаар нь дэмжиж хэрэгжүүлэе. Ингээд хэлчихээр үндэсний үйлдвэрийн бараа үнэтэй, чанаргүй гэж нэг хэсэг нь ам таглах биз. Гэхдээ нэг үеэ бодвол үндэсний үйлдвэрлэл өдөр ирэх тусам хүрээгээ тэлж, өргөжин, хөгжиж байна гэдгийг санах хэрэгтэй болов уу. Үндэсний үйлдвэрлэл гэхээр л “Гоёо” брэндийн ноолууран хувцас, “Монос”-ийн гоо сайхны бүтээгдэхүүнээр хязгаарлагдах цаг ард хоцорсон. Хүнс, гоо сайхан, хувцас, гар урлал, электрон бараа гээд бүхий л салбарт үндэсний үйлдвэрлэгчид байна. Ийм байхад хятадын солжир оймс, буруу хөлтэй тирко, хэрэгтэй хэрэггүй чихэр жимсэнд мөнгөө үрэх ч шаардлага алга. Энд дан ганц үндэсний үйлдвэрлэлээ дэмжих асуудлыг хөндөж байна гэж ойлгож болохгүй. Хамгийн гол нь эдийн засгийн хямралтай үед гадагш чиглэсэн мөнгөний урсгалыг багасгаж, дотооддоо эргэлдүүлэх нь чухал байна гэдгийг ойлгуулах гэсэн төдий. Үнэхээр дотоодын үйлдвэрлэл муу гээд голоод байвал бие биендээ мөнгөнийг нь өгсөн ч болно шүү дээ. Эдийн засгийн хурдацтай уналтын дүнд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ өсч, иргэдийн гар дээр бэлэн мөнгө ховордсон цагт ирсэн зочиндоо мөнгө бэлэглэнэ гэдэг муу сонголт биш. Мөнгө бэлэглэнэ гэхээр заавал их мөнгөөр төсөөлөх хэрэггүй. 1000 төгрөг нэг үндэсний үйлдвэрийн шоколадтай өгөөд ирсэн зочныхоо гарыг цайлагчихад л хангалттай. Монголчуудын нэрэлхүү зан л ётонгоос шоколадны набор, хавсайнаас 20 мянган төгрөг, дэвтэрнээс цамцанд хүргэсэн хэрэг. Цагаан сараар орж ирсэн хүмүүст заавал бэлэг өгдөг нь бэлэгнийхээ том, жижиг, үнэтэй, сайтайд биш ирсэн зочноо гар хоосон гаргадаггүй ардын сайхан уламжлалтай холбоотой гэдгийг л бодох хэрэгтэй. Энд бас нэг зүйлийг сануулахад, цагаан сараар өндөр настай хүнтэй золгохдоо мөнгө барьж золгодог ч больчихмоор л байгаа юм. Бид эрт дээр үеэс ахмад хүмүүстэй хадаг барьж хүндлэн золгодог уламжлалтай. Тэр уламжлалаа л эдийн засгийн хямралтай энэ үед сэргээе. Олон жилийн мөнхийн сэдэв болсон цагаан сараар үндэсний үйлдвэрлэлээ дэмжиж, мөнгөний урсгалаа гадагш гаргахгүй байцгааа гэх уриалгыг л хэрэгжүүлээд ёстой л нэрэлхэлгүй, хороолгүйхэн шиг сар шинийн баяраа тэмдэглэе.

ХОХЬ НЬ БОЛЖ БАЙНА ДАА



Үргэлжлэл.
Түрүүч нь I нүүрт

Тухайлбал, Оросоос байгалийн шатдаг хийг Хятад руу дамжуулах асуудал яригдаж эхэлсэн цагаас Монголоор хоолойг нь явуулах талаар яриа гарсан. Баруун чиглэлээр дамжуулах хоолойны асуудал л даа. “Баруун чиглэл”-ээр гэдэг нь 2006 оноос хойш яригдаж байгаа “Алтай” нэртэй хий дамжуулах хоолойг байгуулах дамжуулах юм. Энэ хоолойг тавих тухай Орос, Хятад хоёр бараг арав орчим жил ярилцаж байгаад барихаар нэгэнт тохиролцоонд хүрсэн. Мэдээж манайх яаж боломжийг зүгээр алдах билээ, Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж шатдаг хийн хоолойн Хятад хүрэх хэсгийг Монголын нутгаар тавихын давуу талыг “зардал бага” “аюулгүй байдал”, “товч зам” хэмээн тодорхойлж, Оросын Ерөнхийлөгч Путиныг манайд айлчлахад хэлж байлаа. Ерөнхийлөгч Путин тухайн үедээ манай даргын энэ саналд ямар нэг тайлбар хийлгүй дуугүй өнгөрсөн.

Тэгээд л хийн хоолой манайхыг дайралгүй, баруун талаар яваад өнгөрөх нь. Уг нь манайхаар дайруулбал хамаагүй ойрхон, үнэ хямд гээд давуу тал ихтэй. Гэвч тэд энэ бүхнийг тоосонгүй. Мөнгөө хэмнэхгүй гэсэндээ биш, манай улстөрчдийн хариуцлагагүй байдал залхаасан учраас тэр. Дөрвөн жил тутамд сонгууль болдог ч засаг нь

...Сая УИХ-ын даргыг Орост очих үеэр ямар хатуу үг шидэж байсан билээ. Хариуцлагагүй гэдгийг улалзтал хэлээ биз дээ. Тэгэхдээ монголчууд гэж тодотгож байгаад дурьдсан. Өндөр дээд албан тушаалтай хүний албан ёсны айлчлал болохоор хамгийн зөөлнөөрөө хэлсэн нь тэр байх...

нэг хоёр их л бол дөрвөөн жил болоод солигддог. Нэг шинэ хүн гарч ирээд, өмнө нь хийсэн бүхнийг үгүйсгэж, арчааг. Уялдаа холбоо байдаггүй. Хамтарч ажиллахаар тохиролцоонд хүрсэн ч хийж чаддаггүй. Улстөржилт нь хэрээс хэтэрчихсэн. Өндөр албан тушаалтнууд нь хувийн амбиц ихтэй, амин хувийн эрх ашгаа нэгдүгээрт тавьдаг. Энэ бүхнээс залхаад хоёр хөрш зугатаж байна. Үгүй ээ, бод доо. Сая УИХ-ын даргыг Орост очих үеэр ямар хатуу үг шидэж байсан билээ. Хариуцлагагүй гэдгийг улалзтал хэлээ биз дээ. Тэгэхдээ монголчууд гэж тодотгож байгаад дурьдсан. Өндөр дээд албан тушаалтай хүний албан ёсны айлчлал болохоор хамгийн зөөлнөөрөө хэлсэн нь тэр байх. Түүнээс биш зад загнамаар санагдсан биз, Оросын талынхан. Япончууд яаж байна. Манайхныг байнга уриалгахан хүлээж авдаг, тусалдаг, дэмждэг. Гэтэл одоо манай дарга нарын элий байл байдлаас залхаж байна шүү дээ. Хятад ч гэсэн хатуурхаж эхэллээ. Энэ бүхэн юунаас болов, манайхны хариуцлагагүй байдлаас, дахин хэлэхэд. Нэг засаг солигдоод, дарга нь өөрчлөгдөөд л гадагшаа айлчлал нэрээр явдаг. Орос, Хятад, Япон руу ихэнхдээ явдаг. Тэгээд

л хамтарч ажиллах гэрээ байгуулаад, санамж бичигт гарын үсэг зураад л давхичихна даа. Худлаа хэлсэн хүнд аль 10 жилийн өмнө байгуулж байсан гэрээгээ л дахин дахин очиж хийгээд байгаа юм шиг л ажилладаг. Өмнөх ажлынх нь үр дүн гардаггүй, хийдэггүй. Шинэ дарга нь өмнөхийнхөө ажлыг үгүйсгэдэг, үргэлжлүүлдэггүй. Шинэ юм яриад л туучихна.

Энэ бүхэн манай улсыг хөсөр хаягдахад хүргээд байна. Үнэндээ хохь нь болоод байна даа. Зарим хүмүүс “Орос, Хятад хоёругаасаа манайхаар юугаа ч дайруулахгүй. Манай улстөрчид үүнийг нь мэддэг ч зүгээр л дайруулна гэж худлаа шуу хийгээд байгаа юм” гэж яриаг дагав. Нэг талаараа үнэн ч байж болох. Гэхдээ л манайхнаас өөр өөртэй хүмүүс байсан бол яаж ийж байгаад төмөр замаа болгө гэхэд хийн хоолойг Монголоор дайруулах талаас нь ажиллах л ёстой байсан. Ажиллаад, зүтгээд, Монголоор дайруулах л байсан юм.

Гэвч чадсангүй, манайхан. Хий л улстөржөөд, сүртэй сүртэй юм яриад байхаас өөрийг хийггүй байна. Одоо Орос, Хятадыг холбосон дэлхийн жишигт нийцсэн хурдны зам тавьчихвал гэх яриа гараад байгаа. Бас л зөв санаачилга. Манайх өөрөө хөрөнгө мөнгөнийхөө асуудлыг шийдээд, ямар ч хамаагүй аргаар Хятадын хилээс Оросын хилд тулгал хурдны зам тавьчих хэрэгтэй шүү дээ. Хэрвээ тэгвэл Ази, Европыг холбосон хамгийн дөт зам манайх болно. Эдийн засгийн өндөр ач холбогдолтой. Зам дагаад үйлчилгээний газрууд бий болно. Улсын орлого нэмэгдэнэ. Юу эсийг тоочиж барах вэ дээ. Гол нь хийх, ажил хэрэг болгох л хэрэгтэй байна.

Тэгэхгүй дөрвөн жилд хэрэлдэж хэрэлдэж, дарга болсон нь баяжиж, баахан хувь хүртчихээд буугаад явчихдаг. Дараагийнх нь гарч ирээд яг тэр замаар нь замнадаг. Өмнөх ажлаа үгүйсгэдэг, байнга тогворгүй байвал яаж өөдлөх билээ дээ. Хөрш орнууд, гадаадын өндөр дээд албан тушаалтнууд бүр аргаа барж, сүүлдээ хэлж байна шүү дээ. Хариуцлагагүй байдлаа л боль гэж. Энэ дөрвөн жил дахиад л бид баахан мөрөөдөл ярьж, орон болгонд айлчилж, шинэ хамтын ажиллагааны санамж бичиг байгуулаад л өнгөрвөл хөөрхий л болох байх даа. Орос, Хятад хоёр лав манайхаас гадуур бүх зүйлээ хийгээд дуусах нь.

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



Ая зохиогч, продюссер
Б. Долгосор

“
 a r o o a o d l i i a i e a a d o e d a e d o d u i
 o a i a e e i o i o d i a a n i i a o b o
 o e e , o i e e i a a d e e a o o a
 n i i a y d e y a a a e i a . A y o y e
 a y e o e e a O e a a i a a a d a d o a a e a a a
 N i e i i a i n u i Y N B - i u a a d e e a a
 o e a a a a d a a a a a o a z e , i d e a o d a i
 a a d e e a u i z a y o y e e o y a e .
 ”

Гэрээ зургийн Г.АРТУУЖИН

ДЭЛХИЙ

БАРАК ОБАМАГИЙН ҮДЭЛТИЙГ ҮГЭЭС ОНЦЛОХ 10 ИШЛЭЛ



Эмиратын Элчин сайд шархадлаа

Афганистаны гурван хотод дэлбэрэлт болжээ. Тодруулбал, тус улсын нийслэл Кабул, Кандахар, Лашкар Гах зэрэг гурван хотод дараалсан дэлбэрэлт болсны улмаас 48 хүн нас барж, 100 орчим хүн гэмтсэн байна. Кабул хотод гэхэд гэмт этгээдүүд Засгийн газрын хоёр ч барилгад тэсрэх бөмбөг тавьсны улмаас хамгийн багаар бодоход 30 хүн нас барж, 80 хүн шархаджээ. Тэдгээр барилгад төрийн агентлагууд байрладаг бөгөөд дэлбэрэлт албан хаагчдыг тарах цагийн үед болсон байна. Халдлагыг Талибаны босогчид үйлдсэн гэдгээ хүлээн зөвшөөрчээ. Харин Кабул хотод дэлбэрэлт болсноос хэдхэн цагийн дараа Кандахар мужийн Кандахар хотын захиргааны байрны дотор байрлах буйданд суурилуулсан тэсрэх бөмбөг дэлбэрч 11 хүн амиа алдсан байна. Дэлбэрэлт болох үед Арабын нэгдсэн Эмират улсаас Афганистанд суух Элчин сайд тус захиргааны байранд зочилж явж таарчээ. Улмаар дэлбэрэлтийн улмаас шархадсан ч амь насанд аюулгүй гэдгийг эх сурвалжууд онцолж байна. Харин гурав дахь хот нь Хелманд мужийн Лашкар Гах хот юм. Тус хотод ч Талибаны бүлэглэлийн нэгэн дайчин амиа золиосолж, долоон хүн нас барсан байна.

Даниэль Ортега Ерөнхийлөгчийн тангаргаа өргөв

Өнгөрсөн оны арваннэгдүгээр сард болсон сонгуулиар Никарагуа улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон Даниэль Ортегагийн тангарга өргөх ёслол боллоо. Тэрбээр төрийн тэргүүнээр гурав дахь удаагаа сонгогдож байгаа юм. Дэд Ерөнхийлөгчөөр түүний гэргий Росарио Мурильо ажиллах ажээ. Никарагуа улсын нийслэл Манагуа хотын Хувьсгалын талбайд ёслолын ажиллагаа болсон байна. Уг ёслолд Венесуэль, Гондурас, Сальвадор улсын Ерөнхийлөгч нар, Тайванийн засаг захиргааны тэргүүн Цай Инвэнь болон Куба, Доминикан улсын төлөөлөгчид оролцжээ. Ерөнхийлөгчийн сонгуульд оролцсон иргэдийн 72 хувь нь Ортегаг дэмжсэн байна. Түүний гол өрсөлдөгч болох Үндсэн хуулийн Либернал намын Максимино Родригес 15 хувийн санал авчээ. Тус улсын Үндсэн хуульд зааснаар, Ерөнхийлөгч болон дэд Ерөнхийлөгчийг таван жилийн хугацаагаар сонгодог байна. Даниэль Ортега дарангуйлагч А.Сомосын дэглэмийн эсрэг зэвсэгт тэмцлийг удирдаж байсан бөгөөд 1985 онд анх Ерөнхийлөгчөөр сонгогджээ. 2007 онд хоёрдахь удаагаа төрийн тэргүүнээр сонгогдсон байна. Түүний удирдлага дор никарагуачууд 2008-2009 оны дэлхийн эдийн засгийн хямралыг даван туулжээ. 2009-2014 оны хугацаанд тус улсад ядуурлын түвшин 42.5 хувиас 29.6 хувь болж буурчээ.

Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт

Тэгвэл Цагаан ордныг орхих хугацаа нь дөхөж буй Барак Обама Ерөнхийлөгчийн хувиар ард түмэндээ хандан сүүлчийн үгээ хэллээ. Түүний үдэлтийн үгийг томоохон мэдээллийн агентлагууд шууд дамжуулан үзүүлсэн юм. Уламжлал ёсоор Цагаан ордноос үдэлтийнхээ үгийг хэлэхийн оронд Барак Обама анх сенатад сонгогдож байсан Чикаго хотод хүрэлцэн иржээ. Улмаар нийт дэмжигчиддээ хандаж, хэзээ ч өөрчлөлт шинэчлэлтэд итгэх итгэлээ алдаж байгаагүйгээ онцолсон байна. Тэрбээр "Бидний хөгжил дэвшил тогтвортой байгаагүй. Ардчилал үргэлж хэцүү, маргаантай, зарим тохиолдолд цус урсгасан байсаар ирсэн. Хоёр алхам урагшлах бүрт нэг алхам хойш ухарч буй мэт санагддаг. Энгийн хүмүүс оролцож, дуу хоолойгоо хүргэж, нэгдэж байж л өөрчлөлт бий болдгийг би эндээс сурсан. Та бүхний Ерөнхийлөгчөөр найман жил ажилласны эцэст би үүнд итгэсэн хэвээр байна. Энэ зөвхөн миний итгэл биш. Энэ бол Америкийн үзэл санааны цохилж буй зурх нь юм" хэмээн дүүрэн хүн цугларсан танхимд хэллээ. Үдэлтийн үгээ хэлж байхдаа Обама нулимс унагаад амжив. Нийт дэмжигч, иргэддээ хандан үг хэлэхдээ гэр бүл,

эхнэр хүүхдээ ч мартсангүй. Б.Обама "Мишель, өнгөрсөн 25 жилийн хугацаанд чи миний эхнэр, хүүхдүүдийн маань ээж байгаад зогсохгүй миний хамгийн сайн найз байсаар ирсэн. Би болон Америк улс чамаар бахархаж байна" гэж хэлэхэд, танхимд сууж байсан бүх хүмүүс босон алга ташиж, Мишель Обамад хүндэтгэл үзүүлээ. Харин "Амьдралдаа хийж, бүтээж байсан бүхнээс илүү би та хоёрын аав болсондоо бахархаж байна" хэмээн охиддоо хандан үгээ хэлэхэд Малина Обама нулимсаа барьж дийлсэнгүй. Дэд ерөнхийлөгч Жо Байден, түүний гэр бүлд ч хандан үг хэлэхэд, танхимд байсан хүмүүс "Би чамд хайртай, Обама!", "Дахиад дөрвөн жил!" хэмээн орилж байлаа. Нэг цагийн турш үргэлжилсэн үдэлтийн үгэндээ тэрбээр өнгөрсөн найман жилд гол гол салбаруудад ямар ямар ололт амжилтыг гаргасан талаараа ярьсан бөгөөд түүний ажил үүгээр зогсохгүй цаашид ч иргэний хувиар ард түмэнтэйгээ хамт байхаа амласан юм. Үг хэлж байхдаа Барак Обама анх сонгуульд нэр дэвшиж байх үедээ ашигласан "Тийм ээ, бид чадна" гэх уриагаа "Тиймээ, бид чадсан" хэмээн өөрчилж байсныг энд дурьдахгүй өнгөрч болохгүй би ээ. Ингээд Барак Обамагийн үдэлтийн үгээс 10 ишлэлийг онцлон хүргэж байна.



- 1 Би 20 гаруйхан насандаа өөрийгөө хэн болох, амьдралынхаа зорилгыг хайж, анх Чикагод ирж байлаа. Тэгээд эндээс холгүйхэн орших хаагдсан гангийн үйлдвэрийн сүүдэрт сүмийнхэнтэй ажиллаж эхэлж билээ. Тэндээс тэмцэл, хомсдолтой нүүр тулан ажиллаж буй хүмүүсийн итгэлийн хүчийг олж харсан. Эгэл жирийн хүмүүс нэгдэж, хамтдаа хөдөлмөрлөснөөр ямар өөрчлөлт гарч болохыг би суралцсан.
- 2 Хэрэв найман жилийн өмнө би улсаа эдийн засгийн хямралаас гаргаж, авто үйлдвэрлэлийн салбарыг сэргээж, ажлын байрыг нэмэгдүүлнэ гэсэн бол. Кубын ард түмэнд түүхийн шинэ хуудас нээнэ, Ираны цөмийн зэвсгийн хөтөлбөрийг зогсооно, эсвэл есдүгээр сарын 11-ний халдлагыг зохион байгуулагчийг олно, гэрлэлтийг эрх тэгш болгоно, 20 сая иргэнээ эрүүл мэндийн даатгалд хамруулна гэж хэлсэн бол та бүгд намайг хэтэрхий өндөрт харж байна гэж хэлэх байсан байх. Гэхдээ бид чадсан. Та нар үүнийг хийсэн. Та нар тэр өөрчлөлтийг хийж чадсан юм шүү. Ард түмний итгэл найдварт хариулт өгч чадсан учраас л Америк орон өдүгээ илүү хүчтэй, илүү сайн сайхан улс болж чадсан.
- 3 Ардчилал нэгдмэл байхыг шаарддаггүй. Ардчиллын үүсгэн байгуулагчид хоорондоо муудалцаж, эвдрэлцдэг. Бид ч гэсэн ялгаагүй, адилхан. Гэхдээ тэд ардчилал эв санааны нэгдэлд суурилах ёстойг мэддэг байсан. Бидний гадаад хэлбэр өөр ч, унасан ч, сэхсэн ч хамт байх нэг үзэл санаатай.
- 4 Ирээдүй биднийх байх учиртай. Гэхдээ ардчилалыг зөв хэрэгжүүлэхгүйгээр хөгжин цэцэглэхгүй. Улс төр гэдэг ард түмний нийтлэг үзэл санааны тусгал байх ёстой. Гэхдээ аль намд харьяалагдах, үзэл санаа ямар байх эсэхээс үл хамааран одоо нэн тэргүүнд бидний хийх ёстой зүйл бол өөрсдийн нийтлэг ардчилалыг бүтээх юм.
- 5 Сонгуулийн дараа арьс өнгөний талаарх яриа Америкт газар авсан. Тийм зүйл болно гэдгийг мэдэж байсан ч яг үнэндээ бодитоор тохиолдоно гэж төсөөлж байсангүй. Арьс өнгөний үзэл одоо ч нийгмийг хуваах хүчтэй хэвээр байгаа. Гэхдээ би арьс өнгөөр ялгаварлан гадуурхах явдал 30, 20, 10 жилийн өмнөхөөс илт сайжирсныг ямар ч статистик мэдээ харахгүйгээр хэлж чадахаар хангалттай удаан амьдарсан.
- 6 Мишель өнгөрсөн 25 жилийн хугацаанд чи зөвхөн миний эхнэр, хүүхдүүдийн минь ээж байсангүй. Миний хамгийн сайн найз байлаа. Чи өөрөө ч хүсээгүй үүрэг хариуцлагыг хүндэтгэлтэй, тэвчээртэйгээр хүлээж өдий хүрэхдээ өөрийн гэсэн хэв маяг, хошин шогийн мэдрэмжээ ч бидэнд харуулж чадсан. Чи л Цагаан ордныг хүн бүхэнд нээлттэй болгож чадсан. Чиний үлгэр дуурайлалаар шинэ үеийнхэн илүү өндөрт хүрэх гэж зорьдог болсон. Би чамаараа маш их бахархаж байна. Улс орон маань ч чамаар бахархаж байгаа.
- 7 Малина, Саша та хоёр минь танил дасал болоогүй ертөнцөд ч ухаалаг, үзэсгэлэнтэй, хамгийн гол нь хэрсүү, хүсэл эрмэлзлэл дүүрэн гайхамшигтай бүсгүйчүүд болж өслөө. Бүгдийн нүдэнд ил амьдрах хүнд ачааг та хоёр минь үүрч гарсан. Амьдралдаа хийж бүтээсэн бүхий л зүйлсээс та хоёрын эцэг болсноороо л аав нь бахархдаг.
- 8 Скрэнтонь өөдөсхөн хүүгээс дэлауэрчүүдийн хайртай хүү болсон Жо Байден. Ерөнхийлөгчийн сонгуульд өрсөлдөж байхдаа чамайг хамтрагчаараа сонгосон минь миний гаргасан хамгийн зөв шийдвэр байлаа. Гэхдээ энэ бол гайхалтай сайн дэд Ерөнхийлөгчийн олж авсны хувьд биш, харин амьдралынхаа ахыг олж авсны хувьд хамгийн зөв шийдвэр байсан юм шүү. Жилл та хоёртоо гэр бүлийнхээ нэгэн адил хайртай. Гэр бүлийн нөхөрлөл бидний амьдралд тохиож байсан хамгийн сайхан зүйлсийн нэг юм.
- 9 Гайхамшигтай хамт олон, алба хаагчдаа, та нар маш ихийг хийж бүтээсэн. Та нарын эрч хүчээс би ихийг олж авсан. Өнгөрсөн хугацаанд өдөр бүр би та бүхний тусгал байхыг хүчээсээр ирсэн. Зүрх сэтгэлээрээ зан чанараараа үзэл баримтлалаараа. Та нар минь өсч өндийхийг, гэр бүл зохиож, үр хүүхэдтэй болохыг амьдралынхаа гайхамшигт аялалаа эхлүүлэхийг харлаа. Хамгийн хүнд хэцүү өдрүүдэд ч та нар Вашингтоны төлөө зүтгэсэн.
- 10 Нийт Америкчуудаа, та бүхэнд үйлчлэх миний хувьд нэр төрийн хэрэг байлаа. Би зогсохгүй. Үлдсэн амьдралынхаа туршид жирийн иргэний хувиар та нартайгаа хамт байх болно. Одоо та нар залуу, эсвэл зүрх сэтгэлдээ залуу байх эсэхээс үл хамааран Ерөнхийлөгчийн хувьд сүүлчийн ганц зүйлийг хүсэмээр байна. Найман жилийн өмнө та бүхэн надад боломж олгох үед хүсч байсан шиг зүйлийг. Би та бүхнийг итгээсэй гэж хүсч байна. Гэхдээ надад бус, өөрсөддөө итгээсэй.

ЦАГ ҮЕ

ЗАСАГ ДАРГА ЯРЬЖ БАЙНА

Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ

Дундговь аймгийн Засаг даргатай цаг үеийн асуудлаар ярилцлаа.

-Дундговьд өвөлжилт онгэй байгаа шинжтэй. Төв аймаг өнгөрмөц цас нимгэрч, зам зуур бэлчих мал сүрэг тарга гэвээрэг сайтай харагдлаа?

-Дундговьчууд өнөтэй сайхан өвөлжиж байна. Тэнгэр хангай ивээн сайхан зун болж, тэр хэрээр газрын гарц сайн гарсан. Малчид маань ч хадлан тэжээлээ боломжийн бэлдсэн. Тиймээс өвлийг ажрахгүй давах болов уу гэж санаж байна. Одоо ихэнх сумдын нутгаар малын хамар хатгах өвстэй, малчдын хувьд сэтгэл тэнгэр өвөлжицгөөж буй. Өвөлжилт хүндэрсэн Төв, Архангай, Говьсүмбэр аймгийн цөөн тооны мал бүхий иргэд манай зарим сумдад оторлож байгаа бол манай малчид ч зөрөөд Булган, Өмнөговь, Дорноговь аймгийн нутагт оторлож байгаа.

-Танай аймаг хөгжлийнхөө ерөнхий төлөвлөгөөг хэрхэн тодорхойлов?

-Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр болон Дундговь аймгийн 2017 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг өнгөрсөн арванхоёрдугаар сарын 2-нд аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж батлуулсан. Тодруулж хэлбэл, Дундговь аймгийг хөгжүүлэх хөгжлийн үндсэн баримт бичиг албажсан гэсэн үг. Миний хувьд 2016 оны долдугаар сарын 26-нд ажил хүлээж авсан. Дашрамд өгүүлэхэд, аймгуудын өрсөлдөх чадварыг



О.БАТ-ЭРДЭНЭ:

ГАДААД, ДОТООД ХАРИЛЦААГАА САЙЖРУУЛЖ, ДЭМЖИЖ БАЙЖ БАЯЛАГ БҮТЭЭХ НЬ

тодорхойлж, байр эзлүүлдэг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв гэж бий. Энэ байгууллагын хийсэн судалгаагаар манай аймаг сүүлийн гурван жил сүүлийн байр эзэлсэн байдаг. Ийм аймаг хүлээж авсан. Тиймээс ажил хүлээж авсан даруйд тус судалгааны төвийн захиралтай уулзаж ярилцахад тэрбээр эдийн засгийн бүхий л үзүүлэлт нь буурсан, аж ахуйн нэгжүүдийн өрсөлдөх чадвар сул байгааг хэлж өгсөн. Үүндээ ч нөхцөл байдал тийм байсан. Өнгөрсөн дөрвөн жилд хэрүүл тасраагүй. Тэгээд бид хоёр ярилцаж байгаад “Нэг говь, нэг зорилго” гэсэн уриан дор говийн гурван аймаг хэрхэн хамтарч өрсөлдөх чадвараа дээшлүүлэх тухайд говийн бүсийн өрсөлдөх чадварын чуулганыг манай аймагт зохион байгуулахаар болсон. Хамгийн гол нь хамгийн муу аймгийн үйл ажиллагаатай газар дээр нь танилц, тэгээд хамтдаа ярилцъя гэсэн хэрэг. Бидний тавьсан саналын дагуу Өмнөговь, Дорноговь, Дундговь тус бүр 20 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг чуулсан. Бид ч боломжийг ашиглан сумдаас 120 хүн нэмж оролцуулсан. Мянга сонсохоор нэг үз гэдэг дээ. Орон нутгийнхан маань ямар зүйл яригддаг, ямар боломж байгаа юм бэ гэдгээ сонсоод, өөрсдийнхөө саналыг хэлж гэж тооцсон. Чуулганыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв, Конрад-Аденауэрын сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Бизнесийн зөвлөл, Монголын үндэсний Худалдаа аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагуудтай хамтран зохион байгуулсан. Энэ үеэр олон сайхан ажил хэрэгч санаанууд гарсан. Хамгийн гол нь ганц аймаг зүтгээд байх биш бусад аймгуудтайгаа нийлж хөгжих ёстой гэдгээ олж харсан. Дундговь геополитикийн хувьд давуу. Улаанбаатар Өмнөговийн тэг дунд нь байх

жишээтэй. Дэд бүтцийн хувьд энэ маань давуу тал шүү дээ. Оюутолгой, Тавантолгой гээд Монгол Улсыг тэжээж байгаа том төслүүд хамар дор минь хэрэгжиж буй. Тэнд өрнөж буй бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд манай аймаг ямар байдлаар хувь нэмэр оруулах вэ, түүнчлэн тэрхүү бүтээн байгуулалтыг аймгийнхаа эдийн засаг руу хэрхэн чиглүүлэх вэ гэдэг нь өөрөө хөгжлийн бодлого чиг хандлага юм байна гэдгийг олж харсан. Мөн хүнд аж үйлдвэрийн хөгжлийн бодлогын суурь болсон Дорноговь аймаг манайхаас ердөө 300 гаруй км-ийн цаана. Ер нь бол барилга байгууламж, дэд бүтцийг аймгийн хөгжил гэж харахгүй байгаа. Хамгийн гол нь иргэдийн амьдрал дэвжин дээшилж, ажилтай, орлоготой болох явдал юм. Тиймээс аймгийн хэмжээнд 21 үйлдвэр байгуулахаар гэсэн том зорилт дэвшүүлж, мөрийн хөтөлбөртөө тусгасан. Гэхдээ энэ үйлдвэрүүд мэдээж хүнд аж үйлдвэр байж чадахгүй. Жижиг, дунд оврын үйлдвэр байна. Хүчин чадлын тухайд хэдий чинээ том байна тэр чинээгээр сайн байх нь ойлгомжтой. Үйлдвэр байгуулагдсанаар ажлын байр тодорхой хэмжээгээр нэмэгдэнэ. Мөн ирэх жил Монгол Улсын хэмжээний шашны болон шинжлэх ухааны нэрт зүтгэлтэн Зава хэмээх Шагдарын Дамдин гавжийн мэлмий гийсний 150 жилийн ой тохиох юм. Энэ хүнийг байгуулсан Дэлгэрийн Чойрын хийд энүүхэнд, 40 гаруй км-ийн зайд том хийд байгаа. Зава Дамдин гавжийн маань хойд дүрээр тодорсон Лувсандаржаа гэгээнтэн буюу эцэг, эхээс заяасан нэрийг нь Осгонбаяр хэмээх хувилгаан лам бий. Зава Дамдин гавжийн 150 жилийн ойг зохион байгуулах комисс байгуулагдаад эдүгээ хэд хэдэн удаа хуралдаад байна. Ойн үеэр баяр наадмаа их өргөн хүрээнд зохион байгуулъя. Шашин

номын болоод соён гэгээрүүлэх ажил, эрдэм шинжилгээний хурлуудыг өргөн хүрээнд томоохон хэмжээнд зохион байгуулна гэсэн төлөвлөгөөтэй ажиллаж байна. Зөвхөн шашин ном, соён гэгээрэл, баяр наадам болгоод өнгөрөлгүй аймагтаа томоохон бүтээн байгуулалтыг хийх, авч үлдэх бодолтой байна.

-Орон нутгийн хөгжлийн санд хэдий хэмжээний мөнгө хуваарилгад. Нууц биш бол юунд зарцуулах вэ?

-Манай аймгийн хувьд орон нутгийн хөгжлийн санд 2.8 тэрбум төгрөг хуваарилгадсан. Энэ хөрөнгөөр бүтээн байгуулалт хийнэ гэвэл нэг хоёрхон зүйл босно. Манай аймаг нийт төсвийнхөө 80 орчим хувийг улсын татаасаар бүрдүүлдэг. Тэгэхдээ бид төсөв хүнд байна гээд гараа хумхин суухгүй ээ. Янз бүрийн гадны төсөл хөтөлбөр, донор байгууллагуудыг орон нутаг руугаа татна. Гадаад, дотоод харилцаагаа сайжруулж, хувийн хэвшилээ бодлогоор дэмжиж байж баялаг бүтэнэ. Ажлын байруудыг шинээр бий болгоно гэсэн бодолтой ажиллаж байна.

-Гадны хөрөнгө оруулагчид Дундговийг хэр сонирхож байх юм?

-Сонирхож байна аа. Эхнээсээ ч саналуудаа ирүүлж байгаа. Тухайлбал, Хонконгийн гаралтай Англи улсын иргэн Гарри Хо гэх бизнесмэн ямааны сүүний ферм байгуулахаар ирсэн. Энэ ферм нь дулаан аргаар ямааны сүүг боловсруулж хүүхдийн тэжээл үйлдвэрлэх юм билээ. Хүүхдийн тэжээлд ямааны сүү хамгийн тохиромжтой аж. Ийм маягаар хувийн хэвшилүүд болоод гадна, дотны санал санаачилгыг дэмжиж ажиллана. Өнгөрсөн хугацаанд Чех, Герман, Франц улсад айлчилж, ажил хэргийн уулзалт хийгээд ирсэн. БНЧУ-ын удирдлагуудтай уулзаж, хөдөө аж ахуйн чиглэлээр хамтарч ажиллахаар санамж

бичигт гарын үсэг зурсан. Мөн дулааны станц барихаар гэрээ нь хийгдсэн ч хөрөнгө оруулалт нь гагцхисан. Улсын хэмжээнд найман аймгийн асуудал яригдаж байгаа юм билээ. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт Тэвшийн говийн нүүрсний ордыг түшиглэн экспортын зориулалттай том чадлын цахилгаан станц, тогтмол гүйдлийн цахилгаан дамжуулах шугам барих төслийг эхлүүлнэ гэж тусгагдсан. Тэвшийн говийн нүүрсний орд аймгаас 30 км-ийн зайтай. Эл ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахын төлөө хөөцөлдөж байна. Ер нь бид бүтээн байгууллаахын зэрэгцээ үйлдвэржилтээ урагшлуулахаар гэсэн бодолтой байгаа.

-Та залуу хүн учраас хөгжлийг өөрөөр харжээ.

Говьд 21 үйлдвэр хаалгаа нээх тухай асуудал хамгийн сайхан мэдээ. Сайхан сонсогдож байна?

-Төр, засгийн бодлого залгамжилж явах учиртай. Өмнөх даргын үед эхэлсэн бүтээн байгуулалт олон бий. Тэднийг эхний ээлжинд дуусгана. Тухайлбал, цэнгэлдэх хүрээлэнгийн барилга. Зураг төсөл нь алдаатай юм билээ. Түүнийг юун түрүүнд засч залруулах ёстой. Түүнчлэн манай аймаг Улаанбаатар Өмнөговийг холбосон хатуу хучилттай замын яг гол хэсэгт оршдог. Улаанбаатараас Оюутолгой, Тавантолгой, Өмнөговь руу явж байгаа хүмүүс яг манай аймгаар үйлчлүүлдэг мөрддөг. Хоолонд орох, амрах, машин тэргээ засч сэлбэх гээд л. Гэтэл манайд чанарын шаардлага хангасан

зочид буудал, нийтийн хоолны газар байхгүй. Хувийн хэвшилүүдээс газар олгоод өгөөч, орчин үеийн шаардлага хангасан зочид буудал, ресторан барьж байгуулъя гэсэн санал ирж байгаа. Энэ бүхнийг бодлогоор дэмжинэ. Тэгээд ч үйлчилгээний байгууллагууд л аймгийн эдийн засагт их нэмэр болдог.

-Үйлдвэрүүдээ хөдөө аж ахуйг түшиглэж байгуулах уу?

-Мэдээж хэрэг манай аймгийн эдийн засгийн хөдөлгөгч хүч нь хөдөө аж ахуй, мал аж ахуй. Хүлэмжийн аж ахуй, барилгын материалын үйлдвэрлэл ч яригдаж буй. Хувийн хэвшилээс ямар санал санаачилга гаргана, түүнийг дэмжиж ажиллана. Өнөөдрийн байдлаар хөрөнгө нь ороод ирчихсэн гэх зүйл алга. Ямартай ч гадны хөрөнгө оруулалтаар хүүхдийн эмнэлэг барих асуудал аман байдлаар шийдэгдсэн.

-Дундговьчууд жилд цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг төр, засгийн чихэнд дуулгадаг. Үүнийг шийдэх боломж ирэх дөрвөн жилд байна уу?

-Нэн даруй шийдэх, шийдвэрлэх асуудлын нэг нь мөн. Цэвэрлэх байгууламжтай болсноор дээр өгүүлсэн 21 үйлдвэрийг барьж ашиглалтад оруулах нөхцөл бүрдэнэ. Үйлдвэрлэл үйлчилгээ хөгжих боломж ч бий болно.

-Говьсүмбэр аймгийн Засаг даргатай уулзаж

УРИЛГА

БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын “Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж “Тээвэр ложистикийн төв” төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага

-Компани татварын өргүй;
-Санхүүгийн чадамжтай;

-Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

Санал авах хугацаа

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд “Монголын төмөр зам” ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг:
“Монголын төмөр зам” Төрийн Өмчит Хувьцаат Компани
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, УВН
центр, 8-р давхар
Улаанбаатар 14230
Утас: (976) 99140072
Факс: (976) 70106644
Вебсайт: www.mtz.mn



ДУУЛГАХ СОНИН

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

Хүүхдэд сонгодог урлагийн боловсрол олгоно

Дуурь бүжгийн эрдмийн театр нь 54 дэх улирлын тоглолтын хүрээнд “Сонгодог урлаг хүүхдийн боловсролд” уриагтайгаар сонгодог урлагаар дамжуулан хүүхдийн боловсрол, ирээдүйн хөгжил төлөвшил, оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие бялдрын зөв хөгжилтэй, гоо зүйн мэдрэмжтэй иргэн төлөвшүүлэх зорилготой ажиллаж байгаа ажээ. Уг үйл ажиллагааны хүрээнд Нийслэлийн Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн газар, есөн дүүргийн зорилтот бүлгийн хүүхдүүд болон Нийслэлийн нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг халамж, асрамжийн төвүүдийн хүүхдүүдийг уг хөтөлбөрт хамруулах чиглэлээр хамтран ажиллахаар болсон байна. Дуурь бүжгийн эрдмийн театр хөтөлбөрт зориулан сар бүр сонгодог урлагийн тоглолтуудыг хүүхдүүдэд зориулан цувралаар зохион байгуулах юм аж. Тус ажлын хүрээнд НХГБХГ-ын дарга Я.Байгаламаа, ДБЭТ-ийн захирал Ч.Мөнхзүл, тус театрын Уран сайхны удирдагч МУАЖ А.Дашпилжээ нар ажил хэргийн уулзалт зохион байгуулж, цаашид хамтран ажиллах чиглэлүүдийн талаар санал солилцжээ. Хөтөлбөрийн нээлт энэ сарын 7-нд ДБЭТ-т болсон бөгөөд “Хөхөө намжил” дууриар эхэлсэн байна. Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр сонгодог урлагийн бүтээлээр дамжуулан хүүхдэд гоо зүйн боловсрол олгох, бие хүний эрэгт төлөвшлийн суурийг тавих боломж бүрдэнэ хэмээн үзэж байгаагаа албаныхан онцоллоо.

“Кубын эрэгт”



Б.ДАВАА

Дэлхийн шилдэг гэрэл зураг шалгаруулах “Sony world photography awards-2016” наадмын нээлттэй төрөлд дэлхийн 186 орны гэрэл зурагчид 103005 бүтээлээ сойжээ. Улмаар бидний өнөөдрийн дугаартаа хүргэж буй зураг “Хүмүүс” төрөлд

тэргүүн байр эзэлсэн байна. “Кубын эрэг” гэх нэртэй энэхүү бүтээлийг 2015 оны дөрөвдүгээр сарын 28-ны өдөр Бразилын чөлөөт гэрэл зурагчин Александр Менегини Гаваннад авчээ. Кубын нийслэл Гаванна хотын далайн эрэгт хүмүүс сэлж байх үед өөрт нь тун чиг хөгжилтэй харагдсан тул гэрэл зурагчин хоёр настай эмэгтэйн

зургийг дурандаа буулгасан нь энэ аж. Тухайн үед гадаа халуун нар төөнөж, 39.7 хэмийн дулаан байсан гэнэ. Тус улсын ус цаг уурын хүрээлэнгээс мэдээлснээр Кубын түүхэнд хамгийн ихдээ 39.8 градус хурч, дулаарч байсан тохиолдол байдаг аж. Харин тэр өдөр үүнээс ердөө 0.1 хэмээр л бага байжээ.

Бидэнд тохиолдсон



ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Оо Phoenix

Яг жилийн өмнө. Үеэл ах чатаар сургана. “За ахын дүү тэгэж болохгүй. Дахиж ингэж болохгүй”. Би “za ahaa bi untlaa”. Маргааш өглөө нь сэрээд, босч ч амжаагүй байхдаа

гэртээ бялга нүүдүүлэв. “Хүнээ байжээ чи” гээд ах зодож байх хооронд өнгөрсөн шөнийнхөө чатыг уншлаа. Би “za shaa bi untlaa”. А, S хоёр дандаа давхар дарагдана шүү. Ха ха ха

“Алтан өд” наадмын шилдгүүд тодорлоо

Монголын зохиолчдын эвлэлээс уламжлал болгон зохион байгуулдаг оны шилдэг бүтээл шалгаруулах “Алтан өд” наадм Монголын зохиолчдын эвлэлийн 88 жилийн ойн өдөр СУИС-ын “Оюутан театр”-т болов. Тус наадм нь яруу найраг, хүүрнэл зохиолын богино болон томоохон хэмжээний бүтээл, жүжиг киноны зохиол, утга зохиолын судлал шүүмж, утга зохиолын орчуулга, баримтат уран зохиолын бүтээл гэсэн есөн төрлөөр шилдгүүдээ тодруулдаг билээ. Мөнхүү шилдэг бүтээл туурвисан залуу уран бүтээлчдэд олгодог Г.Сэр-Одын нэрэмжит шагналыг яруу найрагч Б.Урангоо, С.Начин, Я.Баяраа, Т.Есөн-Эрдэнэ нар хүртэв.

“АЛТАН ӨД-2016” наадмын утга зохиолын шилдэг бүтээлүүд

1. Хүүхдийн уран зохиолын шилдэг бүтээлээр - зохиолч Ш.Энхбаярын “Болжмор, Шоовдор”
2. Хүүрнэл зохиолын томоохон хэмжээний шилдэг бүтээлээр - зохиолч Д.Жамъянгийн “Сарны шувуу”
3. Хүүрнэл зохиолын богино хэмжээний шилдэг бүтээлээр - зохиолч Т.Бум-Эрдэнийн “Дотроосоо”
4. Баримтат уран зохиолын шилдэг бүтээл - зохиолч Л.Дашнямдын “Байх, байх үгүйн дунд”
5. Уран зохиолын судлалын шилдэг бүтээлээр - судлаач, шүүмжлэгч Д.Галбаатарын “Тэгээг хүсэх, Мананд бэдрэх”
6. Уран зохиолын шүүмжийн шилдэг бүтээлээр - зохиолч П.Батхуягийн “Эсрэг цаг-3”
7. Утга зохиолын орчуулгын шилдэг бүтээлээр - зохиолч Д.Дашмөнхийн “Цэвэрхэн саруулхан газар”
8. Жүжиг, киноны шилдэг зохиолоор - Ш.Гүрбазарын “Жаргаагүй нар”
9. Яруу найргийн шилдэг бүтээлээр - яруу найрагч Я.Баяраагийн “Таслал”.



ХӨЛБӨМБӨГ



Конте “Челси”-д Хектор болон Антонио нарыг авчрахыг хүсч байна

Конте “Челси”-д Хектор болон Антонио нарыг авчрахыг хүсч байна Английн “Челси” клубын дасгалжуулагч Антонио Конте энэ өвлийн солилцоо наймааны цонхоор багийнхаа жигүүрийн байрлалыг хүчирхэгжүүлэхийг хичээж байгаа ажээ. Контегийн нэн тэргүүний сонголтгоор Германы “Кёльн” клубын хамгаалагч Йонас Хектор болон “Вест Хэм”-ийн хагас хамгаалагч Мичейл Антонио нар нэрлэгдэж байгаа юм байна. Хекторын хувьд Бундес лигт 16 тоглолтод оролцож, нэг гоолын дамжуулалт өгчихөөд байгаа аж. Тэгвэл Антонио премьер лигийн 19 тоглолтод найман гоол оруулж, нэг гоолын дамжуулалт өгсөн амжилттай яваа билээ.

Э-мэйл: liin_medee@yahoo.com



Улаанбаатарт:

Маргааш

Өдөр -17
Шөнө -27

Нөгөөдөр

Өдөр -16
Шөнө -25

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДҮНД ИЛҮҮ ЦАГААН ХУЛГАНА САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ГАХАЙ ӨДӨР

Наран ургах шингэх: 08.39-17.23
Үс засуулбал: Өлзийтэй сайн



Тухайн өдөр бар, туулай, бич, тахиа жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг луу нөлөөтэй тул элдэв үйлд хяналгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр санасан хэрэг түргэн бүтнэ. Бүтээл үйлдэх, тус чухалчлах, хэл ат даргах, башир, хатуу, түргэн үйл, эт засал хийлгэх, авшиг авах, бэрийн үйл, дайсныг давахад болон хуран чуулах, үс угаахад сайн. Зүүн нүд татвал хувцас олох, баруун нүд татвал тэлцэл болох, баруун чих хангинавал сайн, зүүн нь хангинавал өчүүхэн нэгнийг үзэх, тагнай загатнах, бие татвал үзэсгэлэн болох, хөлийн шөрлөс татвал үг, асуулт болох болой. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, тофь, хонь, нохой, гахай болой.



Галзуу мөрөөдөгчдийн төлөө LA LA LAND

Кино урлагийн дээд шагнал гардуулах 74 дэх удаагийн Алтан бөмбөрцөг ёслолын ажиллагаа амжилттай зохион байгуулагдаж, ялагчдаа тодруулсан билээ. Тэгвэл энэ үдэш “La La Land” кино болон тус бүтээлд хамтран ажилласан уран бүтээлчид амжилтын одыг атган гэрэлтэв. Учир нь тус бүтээл нэр дэвшсэн бүх төрөлдөө ялалт байгуулж, рекорд тогтоожээ.

“La La Land” кино “Шилдэг эрэгтэй гол дүр”, “Шилдэг эмэгтэй гол дүр”, “Шилдэг найруулагч”, “Шилдэг дуу”, “Шилдэг инээдмийн кино”, “Шилдэг дэлгэцийн бүтээл”, “Хамгийн өндөр үнэлгээ авсан” уран бүтээлээр шалгарчээ.

Уг бүтээлийн гол дүрийг хөлийнхүүдийн нэрт жүжигчин Райн Гослинг, Эмма Стоне нар бүтээсэн юм. Энэхүү кино нь инээдэмт, драм, мюзикал гээд ёстой л уран бүтээлийн нэгтгэсэн нийлмэл урлагийг харуулсан бүтээл байлаа.

Киноны нэр давхар утгатай аж. La La Land гэдэг нь нэг талаараа Лос Анжелес хотыг нэрлэсэн нэршил агаад нөгөө талаараа бодит байдлаас тасарсан гэх утгатай үг аж. Киног нь үзсэн даруудаа л бодит байдлаас тасарсан гэх энэ үгийн утгыг илүүтэй ойлгосон юм.

Жааз хөгжимчин Сибастиан жүжигчин болох хүсэл мөрөөдөлтэй бүсгүй Миа нар өөрсдийн хүсэл мөрөөдөлдөө хүрэхийн тулд сонирхолтой адал явдлыг туулдаг. Тэдний адал явдалтай хайрын түүх болоод хүсэл мөрөөдөлдөө хүрэхийн тулд юу юуг туулж байгааг найруулагч Дэмьен Шазель гайхалтай дөрвөн улирлын өнгө, хөгжмийн хэмнэлээр үзэгчдэд хүргэжээ. Ла ла ланд киноны зураг авалт үнэхээр үзэсгэлэнтэй үзэж байхад яаг л олон төрлийн гайхалтай цэцэгсийн мандал

хурдасгаж болдогсон бол босоод бүжиглэж дуулмаар тийм л мэдрэмжийг энэхүү кино өгч чадлаа.

Энэ киног барилгаар төсөөлөхийн бол ёстой л хааны гайхалтай ордон. Бүх л зүйл яаг тохирсон гайхалтай найруулга, сайн жүжигчид, үзэсгэлэнтэй зураглал гээд ямар ч илүү дутуу зүйлгүй сайхан уран бүтээл байлаа.

Хэрэв ээ та энэ киног үзэж амжаагүй бол яаг одоо гэрээсээ гараад кино театр луу очоод

дотор явж байгаа юм шиг мэдрэмжийг төрүүлж байлаа. Түүгээр ч зогсохгүй киноны хөгжим гол дүрийн хоорондын дуулж байгаа хэсэг гээд үнэхээрийн тасаг аялгуутай жинхэнэ мөрөөдөгчдийн ертөнцөд яах аргагүй авч очсон. Хүн бүхэн өөрийн гэсэн хүсэл мөрөөдөлтэй том бага гээд юм юмыг л мөрөөддөг. Тэгвэл “La la land” кино нь надад бас нэгэн мөрөөдлийг нэмж өгсөн юм. Учир би их мөрөөдөлтэй юм л бол мөрөөдөд л мөрөөдөд л байдаг. Монголчууд хэлдэг “Мөрөөдөхөд мөнгө төлөхгүй ээ” гэж үнэхээр үнэн үг шүү. Ерэн бол бүсгүйчүүд их мөрөөдөлтэй байдаг гэсэн нэг судалгаа байдаг юм билээ. Гэхдээ “La la land” ганц эмэгтэйчүүд биш эрчүүдийг ч мөрөөдөлд автуулах бүтээл юм.

Тэр гайхалтай өнгө зураглал, тансаг хөгжим, сонирхолтой үйл явдлыг үзсэн хүн бүхэн кинодоо орж бүр өөрийн эрхгүй зүрхний хэмнэлийг

Галзуу мөрөөдөгчдийн төлөө LA LA LAND

Тэнгис кино театрын дэлгэцнээ 2017 оны 1 сарын 11-нд 13:10, 18:00 цагуудад гарч байна.

Утас: 976-70113551

Факс: 976-70113551

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710